

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТУГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 10

Налайх дүүрэг

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хүрээнд шаардлагатай төлөвлөгөөнүүдийг боловсруулсан. Үүнд:

- Ажилчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөө
- ХАБЭА-н төлөвлөгөө
- Спорт хамтлагийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Монгол Улсын Их хурлаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг баталсантай холбогдуулан байгууллагын ёс зүйн хороо, дүрмийг шинэчлэн баталсан.

Хоёр. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн чиглэлээр

Байгууллагын Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөө гарган ажилласан. Холбогдох газруудаас зохион байгуулсан 16 сургалтад давхардсан тоогоор 41 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан. Үүнд:

- АТГ-ХАСХОМ мэдүүлэгчдэд заавар, зөвлөмж олгох сургалт – 2
- НЗДТГ- Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй, төлөвлөлт, гүйцэтгэлт, тайлагналт, хяналт үнэлгээний сургалт – 2
- НД-ийн Татварын алба – 1
- НАГ- Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудад чиглэл олгох сургалт – 1
- НЗДТГ- Төрийн сангийн төлбөр тооцооны цахим систем нэвтрүүлэлт – 1
- НЗДТГ-ын “Төрөөс стандартчилал, хэмжилзүйн талаар баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” хөтөлбөрийн хэлэлцүүлэлт – 3
- НЗДТГ- стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй – 2
- НДЗДТГ- Амьдралын эрүүл дадад зуршил, харилцаа хандлага сургалт – 8
- НЗДТГ- Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх сургалт -1
- НЗДТГ – Хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлангийн дэд системийн сургалт – 2
- НЗДТГ, ЖАЙКА – Эдийн засаг, санхүүгийн шинжилгээний арга зүй – 1
- НЗДТГ, ЖАЙКА – Төслийн боловсруулалт, эх үүсвэрийн төрөл – 1
- НДЗДТГ – Татварын хуулийн сургалт – 2
- НЗДТГ – Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар танилцуулга, сургалт – 1
- НЗДТГ – Төрийн албан хаагчийн цалингийн программын хөгжүүлэлт – 1

Налайх дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтсээс “Нэгдүгээрт хүүхэд” аяны хүрээнд зохион байгуулсан сургалт – 9 албан хаагч тус тус оролцсон.

Дотоод сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд:


- Монгол бичгийн анхан шатны сургалт
- Хот төлөвлөлт, хот байгуулалтын стандартын барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B, Хог хаягдлын менежментийн стандартын аюултай хог хаягдлын менежмент UCS 1703A, барилгын хог хаягдлын менежмент UCS 1706A, хог хаягдлын устгалын стандарт, устгалын

удирдамж UCS 1705A-г таниулах ажлын хүрээнд паркийн албан хаагчдад сургалт зохион байгуулж байгууллагын 10 албан хаагч хамрагдсан.

- Байгууллагын гамшигийн эрсдэлийн өрөнхий үнэлгээг гүйцэтгэх арга зүйн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 25 албан хаагч оролцсон.

Ажилтнуудад хууль, эрхзүйн мэдлэг олгох "Хуулийн цаг" мэдээллийн цагаар:

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрчлөлт орсон зүйл заалт
- Монгол Улсын Их хурлаас баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдвэл зохих зүйл заалтуудын талаар мэдээлэл өгсөн.





Гурав. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд хууль, дүрэмд нийцүүлэн дараах дэмжлэг, туслалцааг олгосон. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1-т заасны дагуу ар гэрийн гачигдал гарсан 1 албан хаагчид 300,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- Төрийн аудитаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч зөрчилгүй ажилласан санхүү бүртгэлийн 2 албан хаагчийг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсан.
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын хөдөлмөрийн хөлсийг шинэчлэн, 2022 оны 491 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгож байна.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу үнэлж ур чадварын нэмэгдлийг олгосон.
- Албан хаагчдын ажил хөдөлмөрийг үнэлэн Барилга, хот байгуулалтын яамны “Тэргүүний барилгачин” цол тэмдэгээр – 1, “Жуух бичиг”-1, Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдэгээр – 1 албан хаагчийг тодорхойлон хүргүүлсэн.
- Архивчдын баярын өдрийг тохиолдуулан Архивын ерөнхий газрын “Хүндэт жуух” бичгээр 1 албан хаагчийг өргөн мэдүүлж шагнаж урамшуулсан.
- Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулан албан хаагчдад бусад тусламж, дэмжлэг олгогдоогүй болно.
- Ээлжийн амралтын хуваарийн дагуу нийт албан хаагчдад ээлжийн амралтыг олгосон.
- Албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан бичиг хэргийн хэрэгсэл, шаардлагатай техник хэрэгслээр хангасан
- Албан хаагчдын шалтгаан нөхцлийг үндэслэн цалинтай, цалингүй чөлөөг хууль дүрэмд нийцүүлэн олгосон


2023 оны төсөвт ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төсөв тусгагдаагүй тул албан хаагчдыг НД-ийн хөнгөлөлтөөр эрт элрүүлэг шинжилгээнд хамрагдах нөхцөл бололцоогоор ханган ажилласан.

Спорт хамтлагийн ажлын төлөвлөгөө боловсруулан Зуны аялалыг Дорноговь аймаг руу аялахаар төлөвлөн зохион байгуулж, 6 албан хаагч хамрагдсан. Мөн паркуудын дунд зохион байгуулсан спорт тэмцээнд амжилттай оролцсон.



Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, түүх, дурсгалт газруудтай танилцах зорилтын дор Налайх-Төв аймаг Манзуширын хийд-Цэцээ гүний оргил-Налайх маршрутаар явган алхалтыг зохион байгуулсан.

БНСУ-ын Жэжүгийн Үндэсний Их Сургуулийн дэргэдэх SW Convergence боловсролын төвийн WFK Мэдээллийн технологийн сайн дурын багтай хамтран байгууллагын switch, lan утсыг нийтээр нь сольж ажиллах нөхцлийг сайжруулсан.



Мөн ажлын байрны агаарын хэм, чийгшил, дулаан тархалтын нөлөөлөлд ажилтан өдөр бүр (долоо хоногийн 5 өдөр) ажлын 8 цагийн турш өртөхөд бие махбодын үйл ажиллагаанд нь серөг үр дагаврыг бий болгохгүй, хөдөлмөрлөх чадварыг нь бууруулахгүй байх орчинг бүрдүүлж агаарын температурыг 20-24, агаарын чийгшил 30-60 байхаар барьж, шатсан, харласан нийт 10 гэрлийг сольж гэрэлтуулгийн хэвийн байдлыг хангасан.

Дөрөв. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр

Байгууллагад шаардлагатай сүл ажлын байрны зарыг байгууллагын вебсайт, тухайн ажлын байртай холбогдох цахим сайт, фэйж хуудас болон Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтэст мэдээлсэн.

Байгууллагын ажилчидтай холбоотой тусламж, дэмжлэг олгох тушаалыг байгууллагын вебсайт болон шилэн дансны мэдээлэлд тухай бүр нь оруулж байна.

Тав. Хүний нөөцийн мэдээлэл судалгааны чиглэлээр


Тус онд өөрийн хүснэгтээр ажлаас чөлөөлөгдсөн – 3, шинээр ажилд орсон – 3 албан хаагчийн мэдээллийг UB-ERP албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн удирдлагын системийн Хүний нөөцийн модулийн мэдээлэлд тухай бүр нь оруулсан.

НЗДТГ-ын Төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн чиглэлийн дагуу Төрийн албаны “ХНУМТ” цахим системд албан хаагчдын мэдээллийг бүртгэн оруулж Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээр цалин хөлс, урамшууллыг бодон олгож байна.

Хүний нөөцийн шаардлагатай мэдээ, судалгааг холбогдох байгууллагуудад тухай бүр нь хүргүүлсэн.

Зургаа. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан үйл ажиллагааны чиглэлээр

Бүх нийтийн хаврын их цэвэрлэгээ зохион байгуулж байгууллагын ойр орчим болон паркийн 4,63 км бетонон зам дагуух жалгыг цэвэрлэсэн.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж 2023 оны 05 дугаар сарын 18, 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд Городок явах

зам дагуу 140 ширхэг улиас, хайлаас, байгууллагын гадна талбайд 50 шар хуас мод тарьсан.



Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Стратегийн команд штабын сургууль явагдахтай холбогдуулан Зарлан мэдээллийн дохиогоор газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага сургуульд гамшигийн зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллан барилга байгууламжаас гарч “ТҮР ЦУГЛАРАХ” талбайд цугларан өөрсдийн аюулгүй байдлаа ханган оролцлоо.





БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагддаг Кантоны үзэсгэлэн яармагийн 2-р хэсэг болох “Барилгын материалын олон улсын үзэсгэлэн яармаг” нь 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан бөгөөд уг үзэсгэлэнд Инженер Б.Батбилэг, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Чимэгжаргал нар томилогдон ажилласан.



ХЯНАСАН:
ДАРГА

2023 оны дугаар сарын -ны өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЖИЛТАН

С.БАТЖАРГАЛ

Д.НОМИН-ЭРДЭНЭ